



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

“Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд оролцсон
нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн
сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт
гаргах” нийцлийн
АУДИТЫН ТАЙЛАН

Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, хуульд заасан шаардлагад нийцсэн байна.

Аудитын код: ХЭА-2024/13-22-ШТА-НА

Чингис хот 2024 он#

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Ахлах аудитор: Д.Эрдэнэбилэг
Утас: 92116770

Утас: 88032817
Аудитор: Ц.Хатанболд

Утас: 91925552
Т.Алтаншагай

Утас: 92116768

Агуулга

1. Товчилсон үгийн тайлбар	3#
2. Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдээлэл	4#
3. Ерөнхий мэдээлэл:	5#
4. Нэг. Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн байна.	6#
1.1# Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь “Алсын хараа-2050” Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, хуульд заасан шаардлагад нийцсэн байна.....	6#
1.2# Сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байна.	7#
1.3# Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3-д заасан хориглосон зохицуулалттай холбоотой асуудлыг мөрийн хөтөлбөрт тусгаагүй байна.	7#
5. Хоёр. Дүгнэлт.....	8#

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын их хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдээлэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5 , Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5 , Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 -д заасныг тус тус үндэслэн аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлага, "Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал", "Алсын хараа- 2050" Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогод нийцсэн эсэхэд дүгнэлт гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилго чиглэгдэв. Энэхүү зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв.

- Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь “Алсын хараа-2050” Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогод нийцсэн эсэх
- Сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3-д заасан хориглосон зохицуулалттай холбоотой асуудлыг мөрийн хөтөлбөрт тусгасан эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нэр дэвшигч нам, эвсэл, бие даан нэр дэвшигчээс ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, санхүүгийн эх үүсвэр шаардлагатай зорилт арга хэмжээний тооцоо судалгаа, шаардлагатай бусад баримт материалыг хамруулав.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт, АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, судалгаа явуулах арга зүйг ашиглав.

**Аудитын
бүрэлдэхүүн
хугацаа**

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Ганбаатар удирдаж, аудитын үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа хэрэгжүүлж, аудитын багийг аудитор Ц.Хатанболд ахалж, ахлах аудитор Д.Эрдэнэбилэг, Ц.Билэгсайхан, аудитор Т.Алтаншагай нар хөтөлбөрт заасан хуваарийн дагуу гүйцэтгэв.

Ерөнхий мэдээлэл:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5¹, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5², Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4³-д заасныг тус тус үндэслэн аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.10, 37.11-д нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт Төрийн аудитын байгууллага хянаж, дүгнэлт гаргахаар тусгасан байдаг. Дээрх хуульд нам, эвсэл сонгуулийн мөрийн хөтөлбөрийг сонгуулийн жилийн 06 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө, бие даан нэр дэвшигч 07 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө Төрийн аудитын байгууллагад хүргүүлэхээр заагдсан.

Хэнтий аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд 11 улс төрийн нам, 1 эвсэл, 1 бие даан нэр дэвшигч оролцохоор нийт 512 бүлэг, 5878 арга хэмжээ бүхий 68 мөрийн хөтөлбөр ирүүлсэн байна.

Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчээс ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг бүртгэж, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2024 оны А/49 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу сонгуулийн мөрийн хөтөлбөр нь хуулийн заалттай нийцэж байгаа эсэхийг шалгаж дүгнэлт гаргав.

Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийн зорилт арга хэмжээний тоо

Хүснэгт №1

Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн нэр	Аймаг		Сум	
	Мөрийн хөтөлбөрийн тоо	Арга хэмжээний тоо	Мөрийн хөтөлбөрийн тоо	Арга хэмжээний тоо
Ардчилсан нам	1	258	18	2826
Иргэдийн оролцооны нэгдэл нам	1	15		
Иргэдийн хөдөлгөөний нам	1	30	18	540
Иргэний зориг ногоон нам	1	45		
Монгол ардын нам	1	116	18	1264
Монголын хүний төлөө нам	1	85		
Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам	1	179		
Үндэсний эвсэл	1	27		
Үнэн ба зөв нам	1	63		
Хөгжлийн хөтөлбөр нам	1	64		

#####

¹ Энэ хуулийн 11.1, 11.4-т заасан аудитын сэдвийг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудитор аудитын төлөвлөгөөг жилийн болон хэтийн хугацаагаар боловсруулж батална.

² Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогод нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх талаар төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагаар хянуулж, дүгнэлт гаргуулсан байна.

³ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч, Улсын Их Хурлын болон аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох улс төрийн нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь энэ хуулийн 5.3-т заасан баримт бичигт нийцсэн эсэхийг төрийн аудитын байгууллага хянаж, Сонгуулийн ерөнхий хороонд дүгнэлтээ хүргүүлнэ.

Хүн нам	1	148	1	148
Шинэ нам	1	55		
Бие даан нэр дэвшигч Б.Уранчимэг			1	15
Нийт	12	1085	56	4793

Хэнтий аймгийн ИТХ-ын сонгуульд 11 нам, 1 эвсэл өрсөлдөхөөр сонгуулийн мөрийн хөтөлбөртөө 1085 зорилт арга хэмжээг тусгасан бол сумын ИТХ-ын сонгуульд 4 нам, 1 бие даан нэр дэвшигч сонгуулийн мөрийн хөтөлбөртөө 4793 зорилт арга хэмжээг тусгасан байна.

Нэг. Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн байна.

1.1 Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь “Алсын хараа-2050” Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, хуульд заасан шаардлагад нийцсэн байна.

Нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.3-т заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцээгүй зорилт, арга хэмжээ тусгасан 7 намын 24 мөрийн хөтөлбөрийг хуульд заасан шаардлагад нийцээгүй дүгнэлт гаргаж холбогдох улс төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчид хүргүүлсэн.

Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр /Хөгжлийн бодлогод нийцээгүй мөрийн хөтөлбөр арга хэмжээний тоо/

Хүснэгт №2

Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн нэр	Аймаг		Сум	
	Мөрийн хөтөлбөрийн тоо	Арга хэмжээний тоо	Мөрийн хөтөлбөрийн тоо	Арга хэмжээний тоо
Ардчилсан нам			18	112
Монгол ардын нам			4	34
Монголын хүний төлөө нам	1	18		
Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам	1	32		
Үнэн ба зөв нам	1	28		
Хөгжлийн хөтөлбөр нам	1	64		
Шинэ нам	1	55		
Нийт	5	197	22	146

Дээрх хуульд нийцээгүй сонгуулийн мөрийн хөтөлбөрийг арга хэмжээгээр авч үзвэл Монгол Улсын төрөөс орон нутгийн хамгаалалтын талаар баримтлах бодлогод нийцээгүй 84 арга хэмжээ, сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан арга хэмжээнээс зөрүүтэй, тухайн орон нутагт хамааралгүй арга хэмжээ тусгасан, хавсралт маягтыг бүрэн бэлтгэж ирүүлээгүй зэрэг 231 арга хэмжээ байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.9⁴-д заасны дагуу зөрчлийг арилгаж дахин ирүүлсэн улс төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн 21 сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэж хуульд заасан шаардлагад нийцсэн дүгнэлт гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн бол Монголын хүний

#####

⁴ Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр энэ хуульд заасан шаардлага хангаагүй гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд тав хоногийн дотор зөрчлийг арилгасны үндсэн дээр дахин дүгнэлт гаргуулахаар хүргүүлнэ

төлөө нам, Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам, Хөгжлийн хөтөлбөр нам хуулийн хугацаанд сонгуулийн мөрийн хөтөлбөрөө засаж ирүүлээгүй байна.

1.2 Сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байна.

Аймаг, сумдын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчид нь мөрийн хөтөлбөрөө Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тусгай шаардлагад нийцээгүй зөрчил илрээгүй.

1.3 Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3-д заасан хориглосон зохицуулалттай холбоотой асуудлыг мөрийн хөтөлбөрт тусгаагүй байна.

Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дах заалттай нийцээгүй буюу сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгахыг хориглосон арга хэмжээ тусгасан 3 намын 38 мөрийн хөтөлбөрийг хуульд заасан шаардлагад нийцээгүй дүгнэлт гаргаж Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.9-д заасны дагуу зөрчлийг арилгаж дахин ирүүлэхээр хүргүүлсэн.

Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр /Хөгжлийн бодлогод нийцээгүй мөрийн хөтөлбөр арга хэмжээний тоо/

Хүснэгт №2

Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн нэр	Аймаг		Сум	
	Мөрийн хөтөлбөрийн тоо	Арга хэмжээний тоо	Мөрийн хөтөлбөрийн тоо	Арга хэмжээний тоо
Ардчилсан нам			18	90
Иргэний зориг ногоон нам	1	1		
Монгол ардын нам	1	3	18	46
Нийт	2	4	36	136

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тухай хуулийн 37.3-т нийцээгүй арга хэмжээг хуулийн заалтаар авч үзвэл:

Хуулийн заалт	Арга хэмжээний тоо
37.3.1	36
37.3.4	50
37.3.6	54
Нийт	140

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.9⁵-д заасны дагуу зөрчлийг арилгаж дахин ирүүлсэн улс төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн 38 сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэж хуульд заасан шаардлагад нийцсэн дүгнэлт гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн.

#####

⁵ Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр энэ хуульд заасан шаардлага хангаагүй гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд тав хоногийн дотор зөрчлийг арилгасны үндсэн дээр дахин дүгнэлт гаргуулахаар хүргүүлнэ

Хоёр. Дүгнэлт

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.11 , 37.52 , Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.33 -д заасны дагуу сонгуульд өрсөлдөх улс төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигч нь УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулсан 65 мөрийн хөтөлбөрт хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн.

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР